



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2016 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/1107

Улаанбаатар хот

Эссэ бичлэгийн уралдаан зарлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1 дэх заалтуудыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эмч, эрүүл мэндийн ажилтнуудын авъяас чадвар, дотоод нөөц боломжийг нээх, ажлын байран дээрхи үйл ажиллагааг улам боловсронгуй болгох, 2016 оны төлөвлөгөөт ажлыг хэрэгжүүлэх зорилгоор эссэ бичлэгийн уралдааныг зарлан зохион байгуулахыг Хүний нөөцийн хөгжлийн алба, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд үүрэг болгосугай.

2. Эссэ бичлэгийн уралдааны удирдамжыг хавсралтаар баталж, 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 12-ны хооронд эссэ бичлэгийг хүлээн авч, үр дүнг мэргэшсэн албан тушаалтнуудтай хамтран гарган, шалгарсан эссэ бичлэгийг төвийн вэб хуудсанд байршуулан алдаршуулж, шинэ жилийн баярын арга хэмжээнд шагналыг гардуулж урамшуулсугай.


3. Эссэ бичлэгийн уралдааны шагнал урамшуулалд зарцуулах 300,000 /гурван зуун мянга/ төгрөгийг 2016 оны батлагдсан төсөвтөө багтаан зохих зардлаас гаргахыг Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Энхжаргал/-д зөвшөөрсүгэй.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ

000934



ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Зорилго:

Эмч, эрүүл мэндийн ажилтнуудын авъяас чадвар, дотоод нөөц боломжийг нээх, ажлын байран дээрхи үйл ажиллагааг улам боловсронгуй болгох, 2016 оны төлөвлөгөөт ажлыг хэрэгжүүлэх

Сэдэв: “Миний хамт олон хамгийн эрхэм”

“Сэтгэцийн эрүүл мэндийн албаны цаашдын хөгжил”

Хамрах хугацаа:

2016 оны 11 дүгээр сарын 28-нөөс 2016 оны 12 дугаар сарын 12-ны өдөр хүртэл

Хамрах хүрээ:

СЭМҮТ-ийн нийт эмч, эрүүл мэндийн ажилтнууд /1-5 ажилтан хамтран эссэ бичиж болно./

Тавигдах шаардлага:

1. Сэдвийн хүрээнд 1300-1500 үгтэй байна.
2. ЭССЭ нь зөвхөн монгол хэлээр бичигдсэн байна.
3. ЭССЭ нь А4 хэмжээтэй цаасан дээр зүүн талаас 3 см, баруун талаас 2 см, дээр болон доороосоо 2.0 см зайтай Arial фонтоор, 12 хэмжээстэй үсгээр мөр хооронд 1.5 зайтай бичнэ.
4. Зураг, ном зүйг оролцуулж болно.
5. ЭССЭ-ийн эхэнд нэр, зохиогчийн нэрийг заавал бичнэ.
6. ЭССЭ-г сайтар нягталж, шалгасан байх ба үг, үсэг, таслал, цэгийн алдаа мадаггүй байна.
7. ЭССЭ-г цаасан дээр хэвлэсэн 1 хувь, flash дискээр эсвэл цахим шуудангаар mgl_chinos@yahoo.com, sugar_aaaaa@yahoo.com хаягаар ирүүлнэ үү.

Дүгнэх комисс:

- ✓ Хүний нөөцийн хөгжлийн алба
- ✓ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо

Шагнал, урамшууллын сан: 300,000 төгрөг

Жич: Оролцогчдын тооноос хамаарч шалгаруулах байрны тоо, мөнгөн дүнг тогтооно.